



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ХК-ИЙН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: СНАГ-2024/54/НА-СТА-ТӨА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: П.Чанцалдулам
Утас: 261885 Цахим хаяг: chantsaldulamj@audit.gov.mn
Ахлах аудитор: Э.Энхбаатар
Утас: 261628 Цахим хаяг: enkhbaatare@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн "Ихмөнгөл хөлөг Аудит ХХК
-ийн захирал: С.Тунгалаг
Утас: 70001778

Улаанбаатар хот
2024 он

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	6
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан.....	8
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	9
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	10
2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	12
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	14
3.1 Монголын хөрөнгийн бирж ХК, түүний үйл ажиллагаа	14
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	15
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт	16
3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл	17
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	19
4.1 Ерөнхий зүйл	19
4.2 Материаллаг байдал.....	19
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	19
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	19
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	21
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	21
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	22
5.1 Төлбөрийн акт	23
5.2 Албан шаардлага	24
5.3 Зөвлөмж.....	26
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	28
6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл	28
6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл	31
6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	33

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ГВХЗ	Гадаад валютын ханшийн зөрүү
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
СЗХ	Санхүүгийн Зохицуулах Хороо
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
СХЭУГ	Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газар
СЯ	Сангийн яам
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
УИХ	Улсын их хурал
УУББ	Уул уурхайн бүтээгдэхүүний бирж
ХК	Хувьцаат компани
ХОС	Хөрөнгө оруулалтын сан
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХШУ	Хяналт- шинжилгээ, үнэлгээ
ХЭХ	Хувьцаа эзэмшигчдийн хурал



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
ХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Ж.ЦОГТБАЯР
ТАНАА

2024.03.25 № 07/781

танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай санал дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Монголын хөрөнгийн бирж ХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь шинж чанарын хувьд материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Монголын хөрөнгийн бирж ХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Нийт илрүүлсэн татан төвлөрүүлсэн хөрөнгөөс урсгал зардалд зарцуулсан, авлага, өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, төлөөлөн удирдах зөвлөлийн зардлыг хэтрүүлсэн зэрэг зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 461.7 сая төгрөгөөр давсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 20 дугаар зүйлийн 20.2.4, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 зүйлийн 11.8, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.5.11-д заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Монгол Улсын Засгийн газрын "төрийн мэдлийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах төрийн өмчит хуулийн этгээдийн жагсаалт батлах тухай" 2022 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн 244 дүгээр тогтоолоор Монголын хөрөнгийн бирж ТӨХК-ийг олон нийтэд нээлттэй хувьцаат компани болгох шийдвэр гаргасан байна.

Z:\Yawsan_Bichig\2024\03\15 SNAG-66 Docx

0001951657

Санхүүгийн зохицуулах хорооны "Нэмж гаргаж буй үнэт цаасыг нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлд бүртгэх тухай" 2022 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 690 дугаар тогтоолоор нийтэд санал болгон нэмж гаргаж буй нэг бүр нь 100 /нэг зуун/ төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 119,157,603 /Нэг зуун арван есөн сая нэг зуун тавин долоон мянга зургаан зуун гурав/ ширхэг хувьцааг бүртгэн тус компанийн нийт хувьцааг 350,463,539 (гурван зуун тавин сая дөрвөн зуун жаран гурван мянга таван зуун гучин есөн) ширхэг байхаар зөвшөөрлийг олгожээ.

Монголын хөрөнгийн бирж ТӨХК нь анхдагч арилжааг 2022 оны 12 дугаар сарын 26-наас 2022 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн хооронд анхдагч арилжааг амжилттай зохион байгуулж, Хоёрдогч арилжааг 2023 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр эхлүүлсэн байна.

Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2023 оны 04 дүгээр тогтоолоор нэг бүр нь 100 /нэг зуун/ төгрөгийн нэрлэсэн үнэтэй 350,463,539 ширхэг энгийн хувьцаатай буюу 11,915.8 сая төгрөгөөр нэмэгдүүлж, нийт 35,046.4 сая төгрөгөөр компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн дүнг компанийн дүрмээр баталсан байна.

Монголын хөрөнгийн бирж ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор 2022 оны цэвэр ашиг болох 646.2 сая төгрөгөөс ногдол ашиг хуваарилахгүйгээр шийдвэрлэсэн байна.

Аудитын гол асуудал

Монголын хөрөнгийн бирж ХК нь 2022 оны өөрийн хөрөнгийн дүнгийн 3 хувиар буюу 635.8 сая төгрөгийн уул уурхайн биржийн эрсдэлийн санг анх удаа байгуулж, Голомт банканд байршуулсан байна.

Бусад асуудлын хэсэг

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 08 дугаар тогтоолоор компанийн 2022 оны үйл ажиллагааны тайланг 91.0 хувийн хэрэгжилттэй, "Хангалттай", 2023 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 06 дугаар тогтоолоор Санхүүгийн үйл ажиллагааг "Сайжруулах шаардлагатай" гэж дүгнэсэн байна.

Компани нь 2023 онд 3 үндсэн зорилгын хүрээнд 14 зорилтыг хэрэгжүүлэхээр 33 багц ажил, 117 арга хэмжээг төлөвлөсөн ба үйл ажиллагааны тайланд өгөх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт аудитын явцад гараагүй байна.

Монгол Улсын Сангийн яамны Санхүүгийн хяналт удирдлагын газраас Монголын хөрөнгийн бирж ХК-ийн 2023 оны бизнес төлөвлөгөөнд тусгагдсан 3 үндсэн зорилгын хүрээнд 14 зорилтыг хэрэгжүүлэхээр 33 багц ажил, 117 арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж 80.3 хувийн хэрэгжилттэй гэж дүгнэсэн нь өмнөх оны хяналт шинжилгээ үнэлгээний гүйцэтгэлийн үнэлгээнээс 7.3 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Тус хяналт шинжилгээ үнэлгээгээр 12 зөвлөмж хүргүүлсэн байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12 сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	1,731,709,823.18	902,582,814,516.91
1.1.2	Дансны авлага	504,659,308.87	1,868,454,950.77
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	822,948.07	1,457,509.01
1.1.4	Бусад авлага	-	149,471,451.41
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	-	-
1.1.6	Бараа материал	33,650,495.17	36,053,729.65
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	12,775,744.35	204,642,999.30
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	13,160,000.00	-
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)	-	-
1.1.10		-	-
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	2,296,778,319.64	904,842,895,157.05
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	5,536,483,495.31	5,453,061,929.98
1.2.2	Биет бус хөрөнгө	17,648,438,922.95	16,998,953,543.12
1.2.3	Биологийн хөрөнгө	-	-
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	-	-
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	-	-
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	-	-
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	-	-
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө	-	-
1.2.9		-	-
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	23,184,922,418.26	22,452,015,473.10
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	25,481,700,737.90	927,294,910,630.15
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ		
2.1	ӨР ТӨЛБӨР		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	793,176,221.30	265,821,383.36
2.1.1.2	Цалингийн өглөг	-	612,117.37
2.1.1.3	Татварын өглөг	190,085,198.35	341,303,910.22
2.1.1.4	НДШ-ийн өглөг	-	-
2.1.1.5	Богино хугацаат зээл	-	-
2.1.1.6	Хүүгийн өглөг	-	-
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг	-	-
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	15,396,128.31	17,955,656.95
2.1.1.9	Нөөц / өр төлбөр/	-	-
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	-	-
2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө) - д хамаарах өр төлбөр	-	-
2.1.1.12	УУБ-ны арилжааны дэнчинд байршиж буй мөнгө	-	880,962,845,181.82
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	998,657,547.96	881,588,538,249.72
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл	-	-
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/	-	635,862,600.00
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	990,846,139.66	990,698,992.92
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	-	-
2.1.2.5		-	-
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	990,846,139.66	1,626,561,592.92

Монголын хөрөнгийн бирж ХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

2.2	Өр төлбөрийн нийт дүн	1,989,503,687.62	883,215,099,842.64
2.3	Эздийн өмч	23,130,593,600.00	35,046,353,900.00
	Өмч:		
2.3.1	а) төрийн	23,130,593,600.00	23,130,593,600.00
2.3.2	б) хувийн	-	-
2.3.3	в) хувьцаат	-	-
2.3.4	Халаасны хувьцаа		
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал		
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	20,021,146,332.29	20,021,146,332.29
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
2.3.8	Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	446,321,902.02	446,321,902.02
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(20,105,864,784.03)	(11,434,011,346.80)
2.3.11	Эздийн өмчийн дүн	23,492,197,050.28	44,079,810,787.51
2.4	ӨР ТӨЛБӨР ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧИЙН ДҮН	25,481,700,737.90	927,294,910,630.15



2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12 сарын 31
1	Үйл ажиллагааны орлого	4,241,344,850.62	12,147,031,303.89
1.1	Брокер, дилерийн үйл ажиллагааны орлого	4,241,344,850.62	-
1.2	Андеррайтерийн үйл ажиллагааны орлого	-	-
1.3	Үнэт цаасны арилжааны цэвэр орлого	-	12,147,031,303.89
1.4	Үнэт цаасны үнэлгээний тэгшитгэлийн цэвэр орлого	-	-
2	Түрээсийн орлого		
3	Хүүгийн орлого	-	4,562,440,335.78
4	Ногдол ашгийн орлого	-	-
4.1	Хувьцааны ногдол ашиг		
4.2	Хараат болон хамтарсан компаниас олсон ашиг		
5	Эрхийн шимтгэлийн орлого	-	-
6	Бусад орлого	27,070,762.46	13,170,675.00
7	Борлуулалт маркетингийн зардал	-	186,062,107.06
8	Ерөнхий ба удирдлагын зардал	3,557,629,057.47	5,992,598,429.63
9	Санхүүгийн зардал	-	-
10	Бусад зардал	71,765,222.02	19,748,469.36
11	Гадаад валютын ханшийн зөрүүний олз /гарз/	130,867,477.80	(186,717,492.52)
12	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз /гарз/	(141,003.17)	-
13	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз /гарз/	-	-
14	Бусад ашиг /алдагдал/	-	-
15	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	769,747,808.22	10,337,515,816.10
16	Орлогын татварын зардал	123,519,584.56	1,029,799,778.87
17	Татварын дараах ашиг (алдагдал)	646,228,223.66	9,307,716,037.23
18	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг /алдагдал/	-	-
19	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	646,228,223.66	9,307,716,037.23
20	Бусад дэлгэрэнгүй орлого	20,008,784,115.62	-
20.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	20,008,784,115.62	-
20.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
20.3	Бусад олз /гарз/	-	-
21	Орлогын нийт дүн	20,655,012,339.28	9,307,716,037.23
22	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	-	-

Монголын хөрөнгийн бирж ХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан
2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31 - ний үлдэгдэл	23,130,593,600.00	12,362,200.00	446,321,900.00	(19,151,772,700.00)	4,437,505,000.00
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	(1,600,320,300.00)	(1,600,320,300.00)
3	Залруулсан үлдэгдэл	23,130,593,600.00	12,362,200.00	446,321,900.00	(20,752,093,000.00)	2,837,184,700.00
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	646,228,223.66	646,228,223.66
5	Бусад дэлгэрэнгүй орлого	-	20,008,784,100.00	-	-	20,008,784,100.00
6	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-	-
7	Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-	-
9	2022 оны 12-р сарын 31 - ний үлдэгдэл	23,130,593,600.00	20,021,146,332.29	446,321,902.02	(20,105,864,784.03)	23,492,197,050.28
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	(635,862,600.00)	(635,862,600.00)
11	Залруулсан үлдэгдэл	23,130,593,600.00	20,021,146,332.29	446,321,902.02	(20,741,727,384.03)	22,856,334,450.28
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	9,307,716,037.23	9,307,716,037.23
13	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-
14	Өмчид гарсан өөрчлөлт	11,915,760,300.00	-	-	-	11,915,760,300.00
15	Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-	-
17	2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	35,046,353,900.00	20,021,146,332.29	446,321,902.02	(11,434,011,346.80)	44,079,810,787.51

/мөгрөгөөр/



2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12 сарын 31
			<i>/төгрөгөөр/</i>
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	3,914,481,245.55	1,441,824,632,647.89
1.1.1	Бараа борлуулсан үйлчилгээний орлого	3,735,454,914.86	11,595,182,149.63
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	-
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	1,684,791.01	6,128,434.00
1.1.4	Буцаан авсан албан татвар	-	-
1.1.5	Татаас санхүүжилтийн орлого	-	-
1.1.6	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	-	-
1.1.7	Хүлээн авсан хүүгийн орлого	-	4,413,827,379.90
1.1.8	Хүлээн авсан ногдол ашиг	-	-
1.1.9	Бусад мөнгөн орлого	177,341,539.68	1,425,809,494,684.36
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	4,619,870,426.48	544,905,224,391.89
1.2.1	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		238,000,000.00
1.2.2	Ажиллагчдад төлсөн	876,401,679.77	1,778,266,221.02
1.2.3	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	259,137,491.60	512,421,844.47
1.2.4	Бараа материал худалдан авахад төлсөн	35,755,782.00	41,110,050.00
1.2.5	Ашиглалтын зардалд төлсөн	65,253,743.16	111,522,685.60
1.2.6	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	7,674,470.00	1,758,400.00
1.2.7	Хүүгийн төлбөрт төлсөн	-	-
1.2.8	Татварын байгууллагад төлсөн	473,654,111.92	2,058,142,678.97
1.2.9	Даатгалын төлбөрт төлсөн	-	5,000,000.00
1.2.10	Зохицуулалтын хөлс, шимтгэл хураамжид төлсөн	-	566,128,324.18
1.2.11	Бусад мөнгөн зарлага	2,901,993,148.03	539,592,874,187.65
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(705,389,180.93)	896,919,408,256.00
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.3	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.4	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	-	-
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	423,392,511.67	575,344,268.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	286,663,700.00	347,651,580.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	136,728,811.67	227,692,688.00
2.2.3	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.4	Бусдад олгосон зээл, болон урьдчилгаа	-	-
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(423,392,511.67)	(575,344,268.00)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	11,915,759,800.00
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
3.1.2	Хувьцаа болон өмчийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	11,915,759,800.00

3.1.3	Төрөл бүрийн хандив	-	-
3.1.4	Бусад мөнгөн орлого	-	-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	-
3.2.1	Зээл авсан, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн мөнгө		
3.2.3	Хувьцаа буцааж худалдан авахад төлсөн мөнгө		
3.2.4	Төлсөн ногдол ашиг		
3.2.5	Бусад мөнгөн зарлага		
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	11,915,759,800.00
4	Валютын ханшийн зерүү	131,127,879.87	(7,408,719,094.28)
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(997,653,812.73)	900,851,104,693.72
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,729,363,635.92	1,731,709,823.19
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,731,709,823.19	902,582,814,516.91



2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Хувь
A	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ОРЛОГО	9,783,712.0	16,722,642.3	6,938,930.3	170.9
1	Хувьцааны арилжааны шимтгэл	2,767,633.0	2,464,641.7	(302,991.3)	89.1
2	Бондын арилжааны шимтгэл	1,270,395.0	91,084.1	(1,179,310.9)	7.2
3	ХОС-ын нэгж эрх арилжааны шимтгэл	74,396.0	42,744.5	(31,651.5)	57.5
4	Нүүрсний арилжааны шимтгэл	2,454,494.0	6,678,704.5	4,224,210.5	272.1
5	Төмөр жоншны арилжааны шимтгэл	98,437.0	176,516.7	78,079.7	179.3
6	Гишүүнчлэлийн жилийн хураамж	76,590.0	109,282.2	32,692.2	142.7
7	Терминал ашигласны хураамж	71,760.0	63,411.0	(8,349.0)	88.4
8	Бүртгэл үйлчилгээний орлого	1,784,419.0	1,562,579.9	(221,839.1)	87.6
9	Бүртгэлтэй компанийн жилийн хураамж	432,581.0	391,385.3	(41,195.7)	90.5
10	Сургалтын орлого	40,000.0	8,181.8	(31,818.2)	20.5
11	Мэдээлэл үйлчилгээний орлого	202,557.0	163,918.7	(38,638.3)	80.9
12	Хүүгийн орлого	397,500.0	4,562,440.3	4,164,940.3	1,147.8
13	Бусад орлого	112,950.0	407,751.6	294,801.6	361.0
14	МИТ ашиглалтын орлого	-	-	-	-
B	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ЗАРДАЛ	6,698,000.0	6,198,409.0	(499,591.0)	92.5
1	Ажилтнуудын цалин хөлс	2,245,935.0	2,060,917.4	(185,017.6)	91.8
2	НДШ-ийн зардал	296,451.0	257,179.0	(39,272.0)	86.8
3	Удирдлагын зардал/ТУЗ-ийн/	151,387.0	152,809.5	1,422.5	100.9
4	Материал, бичиг хэрэг	31,248.0	31,779.0	531.0	101.7
5	Харилцаа холбооны зардал	8,624.0	7,709.4	(914.6)	89.4
6	Интернэт ашиглалт	22,424.0	15,483.9	(6,940.1)	69.1
7	Шатахуун, тээврийн хэрэгслийн зардал	10,000.0	1,213.4	(8,786.6)	12.1
8	Цахилгаан үүсгүүр цэнэглэлт	896.0	492.4	(403.6)	55.0
9	Урсгал засвар	56,088.0	23,510.0	(32,578.0)	41.9
10	Цахилгаан, дулаан, ус хог	59,589.0	54,906.9	(4,682.1)	92.1
11	Албан томилолт	83,969.0	35,085.7	(48,883.3)	41.8
12	Сургалт семинар	69,372.0	26,508.6	(42,863.4)	38.2
13	Ажилтнуудын нийгмийн зардал	36,000.0	4,465.0	(31,535.0)	12.4
14	Зах зээл идэвхжүүлэлт, бизнес харилцааны зардал	66,375.0	47,300.4	(19,074.6)	71.3
15	Хувьцаа эзэмшигчдийн хурал зохион байгуулалтын зардал	43,358.0	37,760.4	(5,597.6)	87.1
16	Мэдээлэл технологийн зардал	149,370.0	111,367.0	(38,003.0)	74.6
17	Бусад зардал	232,580.0	74,475.2	(158,104.8)	32.0

Монголын хөрөнгийн бирж ХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

18	Элэгдлийн зардал	928,994.0	609,066.1	(319,927.9)	65.6
19	Зохицуулах үйлчилгээний хөлс	195,861.0	704,567.0	508,706.0	359.7
20	МIT ашиглалтын зардал:	1,771,479.0	1,703,812.9	(67,666.1)	96.2
	Үүнд: Элэгдлийн зардал	684,336.0	684,335.7	(0.3)	100.0
	MIT ашиглалтын зардал:	1,087,143.0	1,019,477.2	(67,665.8)	93.8
21	IPO зөвлөх үйлчилгээний зардал	238,000.0	238,000.0	-	100.0
B	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АШИГ АЛДАГДАЛ	3,085,712.0	10,524,233.3	7,438,521.3	341.1
4	Гадаад валютын ханшийн зөрүүний олз/гарз	52,930.0	186,717.5	133,787.5	352.8
5	ТАТВАРЫН ӨМНӨХ ЦЭВЭР АШИГ (B+Г)	3,032,782.0	10,337,515.8	7,304,733.8	340.9
6	Нийт авлага/Цэвэр/	51,460.0	2,019,383.9	1,967,923.9	3,924.2
7	Нийт өглөг/MIT зардал оруулж тооцсоноор/	218,319.0	883,215,099.8	882,996,780.8	404,552.6
8	Ногдол ашиг хуваарилалт	-	-	-	-
9	Ажиллагсдын тоо	69.0	70.0	1.0	101.4
10	Борлуулалтын 1 төгрөгт ногдох үйл ажиллагааны зардал	0.7	0.4	(0.3)	53.0
11	Хөрөнгө оруулалт	5,626,411.3	1,028,728.0	(4,597,683.3)	18.3



3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Монголын хөрөнгийн бирж ХК, түүний үйл ажиллагаа

Монголын хөрөнгийн бирж ХК нь Үндэсний үйлдвэрлэл, үйлчилгээг сэргээн хөгжүүлэх, дотоод, гадаадын хөрөнгө оруулалтыг идэвхжүүлэх, дэмжин урамшуулахад үйл ажиллагаагаа чиглүүлж, үнэт цаасны зах зээлийг сонгодог утгаар нь төлөвшүүлэн хөгжүүлэх, уул уурхайн бүтээгдэхүүний арилжааг нээлттэй ил тод зохион байгуулах зорилгын хүрээнд явуулдаг, Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм.

Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2023 оны 8 дугаар тогтоолоор Монголын хөрөнгийн бирж ХК-ийн үндсэн үйл ажиллагааны чиглэлийг компанийн дүрэмд дараах байдлаар өөрчлөн найруулсан байна. Үүнд:

- Үнэт цаасны зах зээлд үнэт цаасны болон уул уурхайн бүтээгдэхүүний арилжаа эрхлэх, тооцооны болон өөрийгөө зохицуулах байгууллагын үйл ажиллагаа, хуулиар зөвшөөрсөн бусад арилжаа, эрхлэх;
- Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан зохицуулалттай этгээд болох арилжаа эрхлэх болон өөрийгөө зохицуулах байгууллагын хувь мөн Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааг гүйцэтгэгчийн хувьд хуульд заасан дүрэм, журмыг баталж мөрдүүлэх, арилжаа зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих, үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх;
- Тодорхой мэргэжил, тусгай зөвшөөрөл шаардагдах үйл ажиллагаа явуулах, тохиолдолд холбогдох эрх бүхий байгууллагаас зохих зөвшөөрөл авч улсын бүртгэлд бүртгүүлсний үндсэн дээр тухайн үйл ажиллагааг эрхлэх.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллага нь Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Аудитын тухай хууль, Төрийн аудитын тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай тухай хууль, Татварын ерөнхий хууль, Зөрчлийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай УИХ-ын 2022 оны 72 дугаар тогтоол зэрэг хууль эрх зүйн баримт бичгийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна.

Тайлант хугацаанд биржийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Тухайлбал:

- Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулга;
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийн шинэчилсэн найруулга;
- Төрийн аудитын тухай хуулийн нэмэлт өөрчлөлт;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулга;
- Нийгмийн даатгалын ерөнхий хууль;
- Уул уурхайн биржийн тухай хууль;
- Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны "Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны зуучлагч (брокер)-ийн үйлчилгээний төлбөр, хураамж"-ийг тогтоох тухай 793 дугаар тогтоол;
- Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны "Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр банкнаас бусад мэдээлэх үүрэгтэй этгээдэд зайны болон газар дээрх, хяналт шалгалт хийх журам"-ыг шинэчлэн батлах тухай 22 дугаар тогтоол;
- Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны "Төмрийн хүдэр, баяжмалын арилжааны гэрээний стандартыг тогтоох, мөрдүүлэх журам" батлах тухай 458 дугаар тогтоол;

- ТУЗ-ийн 2023 оны "Хайлуур жоншны хүдэр баяжмалын арилжааны гэрээний стандартыг тогтоох, мөрдүүлэх журам" батлах тухай 32 дугаар тогтоол;
- ТУЗ-ийн 2023 оны "Экспортод гаргах нүүрсний нээлттэй цахим арилжааг зохион байгуулах заавар"-ыг батлах тухай 03 дугаар тогтоол;
- ТУЗ-ийн 2023 оны "Уул уурхайн бүтээгдэхүүний спот, форвард арилжааны эрсдэлийн сан байгуулах тухай" 52 дугаар тогтоол;
- ТУЗ-ийн 2023 оны "Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах тухай" 08 дугаар тогтоол;
- ХЭХ-ын 2023 оны Монголын хөрөнгийн бирж ХК-ийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах тухай 05 дугаар тогтоол;
- ХЭХ-ын 2023 оны Монголын хөрөнгийн бирж ХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг тогтоох тухай 04 дүгээр тогтоол;
- ХЭХ-ын 2023 оны "ТУЗ-ийн гишүүдийг томилох тухай" 07 дугаар тогтоол;
- ХЭХ-ын 2023 оны Монголын хөрөнгийн бирж ХК-ийн Хяналтын зөвлөлийн ажиллах журам"-ыг батлах тухай 09 дүгээр тогтоол;

Компанийн удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

ТУЗ-ийн 2023 оны 20 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан бүтэц, зохион байгуулалтаар 2 орон тоотой, дотоод хяналтын алба ажиллахаар баталсан ба уг алба нь Компанийн гүйцэтгэх захирлын 2016 оны 167 дугаар тушаалаар баталсан "Дотоод хяналт шалгалтын журам"-ыг мөрдөж байна.

Дотоод хяналтын алба нь тайлант онд гүйцэтгэх ажлын батлагдсан төлөвлөөгүй, хяналт шалгалтыг 1 удаа хийж 3 зөвлөмж хүргүүлсэн боловч хэрэгжилтийг тооцоогүй байна.

Компанийн ХЭХ-ийн 2023 оны 09 дүгээр тогтоолоор Монголын хөрөнгийн бирж ХК-ийн "Хяналтын зөвлөлийн ажиллах журам"-ыг баталж, 2023 оны 10 дугаар тогтоолоор Хяналтын зөвлөлийн гишүүнээр 3 нэр дэвшигчийг 2 жилийн хугацаатайгаар томилсон байна. Аудитын явцад хяналтын зөвлөлийн тайланг ирүүлээгүй болно.

Дотоод аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Монголын хөрөнгийн бирж ХК-ийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн дагуу Мишээл-Од Аудит ХХК-тай МХ52023/536 тоот, Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулах зөвлөх үйлчилгээний гэрээг 2023 оны 10 дугаар сарын 17-ны өдөр байгуулсан байна. Уг гэрээт ажлыг 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор гүйцэтгэж, хүлээлгэн өгөх гэрээний заалт хэрэгжээгүй байна.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцээгүй, үйл ажиллагааны онцлогт бүрэн тохироогүй компанийн үйл ажиллагаатай холбоотой эрх бүхий

байгууллагуудаас шинээр баталсан хууль, заавар, журамд нийцүүлэн ажил гүйлгээг бүртгэх, тайлагнах, арга аргачлалыг тодорхойлж тусгаагүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Монголын хөрөнгийн бирж ХК-ийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 901,813.2 сая төгрөгөөр буюу 36.4 дахин өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	1,731,709.8	902,582,814.5	900,851,104.7
Авлага	518,258.0	2,224,026.9	1,705,768.9
Бараа материал	33,650.5	36,053.7	2,403.2
Бусад эргэлтийн хөрөнгө	13,160.0	-	(13,160.0)
Үндсэн хөрөнгө	23,184,922.4	22,452,015.5	(732,906.9)
Нийт хөрөнгийн дүн	25,481,700.7	927,294,910.6	901,813,209.9
Өр төлбөр	1,989,503.6	883,215,099.8	881,225,596.2
Эздийн өмчийн дүн	23,492,197.1	44,079,810.8	20,587,613.7
Өр төлбөр эзэмшигчдийн өмчийн дүн	25,481,700.7	927,294,910.6	901,813,209.9

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө өмнөх оноос 900,851.1 сая төгрөгөөр өссөн нь уул уурхайн биржийн арилжаанд оролцогчдын дэнчинд байршуулсан 880,962.9 сая төгрөг, татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулаагүй үлдэгдэл 10,428.6 сая төгрөг, уул уурхайн биржийн эрсдэлийн сангийн Голомт банканд тусгаарласан 635.9 сая төгрөг, тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагааны орлого нэмэгдсэнээс мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 8,823.7 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн;
- Авлагын дансны үлдэгдэл өмнөх оноос 1,705.8 сая төгрөгөөр өссөн нь дансны авлага 1,363.8 сая төгрөг, татвар, НДШ-ийн авлага 0.6 сая төгрөг, бусад авлага 149.4 сая төгрөг, урьдчилж төлсөн зардал тооцоо 191.9 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн;
- Бараа материалын дансны үлдэгдэл өмнөх оноос 2.4 сая төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд 37.2 сая төгрөгийн хангамжийн материал худалдан авч, үйл ажиллагаанд 34.8 сая төгрөгийн хангамжийн материал зарцуулсантай холбоотой;
- Бусад эргэлтийн хөрөнгө өмнөх оноос 13.2 сая төгрөгөөр буурсан нь Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сум дахь шалгагдагч байгууллагын эзэмших эрх бүхий газар тариалангийн зориулалттай 304 га газрыг биет бус хөрөнгөөр залруулж бүртгэсэнээс шалтгаалсан;
- Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл өмнөх оноос 732.9 сая төгрөгөөр буурсан нь ТУЗ-ийн 2023 оны 27 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дагуу 560.5 сая төгрөгийн хөрөнгө худалдан авч, тайлант хугацаанд 1,293.4 сая төгрөгийн элэгдэл байгуулснаас шалтгаалсан;
- Өр төлбөрийн дансны үлдэгдэл өмнөх оноос 881,225.6 сая төгрөгөөр өссөн нь цалингийн өглөг 0.6 сая төгрөг, урьдчилж орсон орлого 2.6 сая төгрөг, татварын өглөг 151.2 сая төгрөг, анх удаа уул уурхайн биржийн эрсдэлийн санг, өөрийн хөрөнгийн 3 хувиар байгуулж бүртгэсэн 635.9 сая төгрөг, уул уурхайн биржийн арилжаанд оролцогчдын байршуулсан дэнчингийн буцаан төлөх төлбөр 880,962.9 сая төгрөгөөр

тус тус өсөж, хойшлогдсон татварын өр 0.2 сая төгрөг, дансны өглөг 527.4 сая төгрөгөөр тус тус буурснаас нөлөөлсөн;

- Эздийн өмчийн дүн өмнөх оноос 20,587.6 сая төгрөгөөр өссөн нь ХЭХ-ын 2023 оны 04 дүгээр тогтоолоор компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийг нэг бүр нь 100 /нэг зуун/ төгрөгийн нэрлэсэн үнэтэй 350,463,539 ширхэг энгийн хувьцаатай буюу нийт 35,046.4 сая төгрөг буюу 11,915.8 сая төгрөгөөр нэмэгдүүлж, тайлант хугацаанд 8,671.9 сая төгрөгийн ашигтай ажилласантай холбоотой байна.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Монголын хөрөнгийн бирж ХК-ийн үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө /техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Компанийн ХЭХ-ын 2023 оны 03 дугаар тогтоолоор эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөд нийт орлогыг 9,429.5 сая төгрөгөөр, нийт зардлыг 6,576.3 сая төгрөгөөр, 2,853.2 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллахаар баталж, хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 726.8 сая төгрөгийг төлөвлөжээ.

ТУЗ-ийн 2023 оны 8 дугаар сарын 31-ны өдрийн 29 дүгээр тогтоолоор орлого, зардлын төлөвлөгөөнд тодотгол хийж төмөр жоншны арилжааны шимтгэлийн орлогын төлөвлөгөөг 98.4 сая төгрөг, нүүрсний арилжааны орлогын төлөвлөгөөг 255.8 сая төгрөг, нийт 354.2 сая төгрөгөөр нийт орлогыг нэмэгдүүлж, ажилтнуудын нийгмийн зардлыг 6.5 сая төгрөг, шатахуун тээврийн хэрэгслийн зардлыг 10.0 сая төгрөг, мэдээлэл технологийн зардлыг 18.6 сая төгрөг, удирдлагын зардлыг 18.8 сая төгрөг, бусад зардлыг 141.7 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлж, зах зээл идэвхижүүлэлт, бизнес харилцааны зардлыг 73.9 сая төгрөгөөр бууруулан нийт зардлыг 121.7 сая төгрөгөөр нэмэгдүүлж, тайлант оны нийт орлогыг 9,783.7 сая төгрөг, нийт зардлыг 6,698.0 сая төгрөг, 3,032.8 сая төгрөгийн ашигтай ажиллахаар баталсан байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээний зардлыг 65.6 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 792.4 сая төгрөгийг төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 16,722.6 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 6,198.4 сая төгрөгийн зардал гарган, 10,524.2 сая төгрөгийн татварын өмнөх ашигтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 16,722.6 сая төгрөг болж төлөвлөснөөс 6,938.9 сая төгрөг буюу 70.9 хувиар давсан нь гишүүнчлэлийн жилийн хураамж 32.7 сая төгрөг, төмөр, жоншны арилжааны шимтгэл 78.1 сая төгрөг, бусад орлого 294.8 сая төгрөг, хүүгийн орлого 4,164.9 сая төгрөг, нүүрсний арилжааны шимтгэлийн орлого 4,224.2 сая төгрөгөөр тус тус давж, терминал ашигласны хураамж 8.4 сая төгрөг, ХОС-ын нэгж эрхийн арилжааны шимтгэл 31.7 сая төгрөг, сургалтын орлого 31.8 сая төгрөг, мэдээллийн үйлчилгээний орлого 38.6 сая төгрөг, бүртгэлтэй компанийн жилийн хураамж 41.2 сая төгрөг, бүртгэл үйлчилгээний орлого 221.8 сая төгрөг, хувьцааны арилжааны шимтгэлийн орлого 303.0 сая төгрөг, бондын арилжааны шимтгэлийн орлого 1,179.3 сая төгрөгөөр тус тус тасарсантай холбоотой байна.

Нийт зардлын гүйцэтгэл 6,198.4 сая төгрөг болж, төлөвлөснөөс 500.0 сая төгрөгөөр бага буюу 92.5 хувийн гүйцэтгэлтэй байна. Энэ нь бичиг хэргийн зардал 531.0 сая төгрөг, ТУЗ-ын зардал 1.4 сая төгрөг, зохицуулах үйлчилгээний хөлс 508.7 сая төгрөгөөр тус тус өсөж, бусад үйл ажил ажиллагааны зардал 1,010.3 сая төгрөгөөр дутуу зарцуулсан нь гол нөлөө үзүүлсэн байна.

Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу 6 нэр төрлийн ажилд өөрийн эх үүсвэрээс 448.5 сая төгрөг, татан төвлөрүүлсэн хөрөнгөөс 500.8 сая төгрөгийн зардлыг тус тус санхүүжүүлсэн байна.

Тайлант онд цэвэр ашиг 10,337.5 сая төгрөг болж, төлөвлөснөөс 7,304.7 сая төгрөгөөр илүү байгаа нь хүүгийн орлого 4,164.9 сая төгрөг, нүүрсний арилжааны шимтгэлийн орлого 4,224.2 сая төгрөгөөр тус тус давж биелсэн нь нөлөөлжээ.

ТУЗ-ийн 2023 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор 2022 оны цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилахгүйгээр шийдвэрлэсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Монголын хөрөнгийн бирж ХК-ийн 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн компани, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн Компанийн үйл ажиллагааг сайжруулахаар үндсэн хөрөнгө, дотоод хяналт, татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалттай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Ихмонгол хөлөг Аудит ХХК-ийн ахлах аудитор Г.Ариунбат, аудитор О.Эрдэнэчимэг нар гүйцэтгэж, чанарын хяналтын менежер С.Сождимаа, компанийн захирал С.Тунгалаг нар анхан шатны чанарын хяналтыг, Санхүү-нийцлийн аудитын газрын ахлах аудитор Э.Энхбаатар, аудитын менежер П.Чанцалдулам, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны чанарын хяналтыг хэрэгжүүлсэн.

Монголын хөрөнгийн бирж ХК-ийн 2023 оны санхүүгийн тайлангаа Үндэсний аудитын газарт 2023 оны 2 дугаар сарын 16-ны өдрийн 01/22 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны тодотгосон эдийн засгийн үндсэн үзүүлэлт зорилтот түвшний нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны зорилтот түвшний нийт зардал 6,698.0 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 67.0 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Монголын хөрөнгийн бирж ХК нь 72 орон тоотойгоор ажиллахаас 65 орон тоотой ажиллаж, цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардлаас 185.0 сая төгрөгийн хэмнэлтийг бий болгож ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн нийт 1,857.0 сая төгрөгийн зөрчлөөс 1.2 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 1,855.8 сая төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өглөө.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг

тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант оны шилэн дансны нэгдсэн цахим хуудсыг шалгахад нийт 74 мэдээлэл байршуулахаас хугацаандаа оруулсан 31, оруулах мэдээлэл байхгүй 43 мэдээлэл байна. Цалингаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлого, зарлагын гүйлгээг хугацаанд нь оруулсан байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

1. Шалгагдагч байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 1 суудлын автомашины улсын дугаар цагаан өнгөтэй байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-д "Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй бүх төрлийн авто тээврийн хэрэгсэлд бусад авто тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглэнэ." гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Авто тээврийн хэрэгслийг тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаартай болгох зөвлөмж өгөв.

2. ТУЗ-ын 2023 оны 27 дугаар тогтоолоор 13 нэр төрлийн 9,783.7 сая төгрөгийн орлогын төлөвлөгөөг баталснаас гишүүн байгууллагын хураамжийн орлого, төмрийн арилжааны шимтгэл, бусад орлого, банкны хүүгийн орлого, нүүрсний арилжааны шимтгэлийн орлого нийт 5 төрлийн орлогын төлөвлөгөө 32.7-4,224.2 сая төгрөгөөр давж, 8 нэр төрлийн орлогын төлөвлөгөө 8.3-1,179.3 сая төгрөгөөр тасарсан байна.

Энэ нь Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.6-т "Гүйцэтгэх удирдлага нь төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/-тэй байгуулсан гэрээний үндсэн дээр үйл ажиллагаагаа явуулна, Компанийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.10.1-д "Энэхүү дүрэм болон холбогдох хууль тогтоомж, хувьцаа эзэмшигчдийн хурлын болон ТУЗ-өөс өгсөн үүрэг, чиглэл, шийдвэр, үүрэг даалгаврыг биелүүлэх ажлыг зохион байгуулж, гүйцэтгэлийг хангуулж, ТУЗ-д тайлагнах, Монголын хөрөнгийн бирж ХК-ийн гүйцэтгэх захирал болон төлөөлөн удирдах зөвлөлийн хоорондын хөлсөөр ажиллах №2017/01 дүгээр гэрээний 3 дугаар зүйлийн 3.1-т "Гүйцэтгэх захирал нь компанийн тухайн жилийн үйл ажиллагааны зорилтот түвшин, ТУЗ-ийн баталсан бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлэх, компанийн ашиг орлогыг нэмэгдүүлэх үндсэн үүрэгтэй." гэж заасныг тус тус мөрдөөгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Орлогын төлөвлөгөөний биелэлтийг нэр төрлөөр ханган биелүүлэх, зорилтот түвшний орлого зарлагын төлөвлөгөөг үндэслэлтэй төлөвлөж байх зөвлөмж өгөв.

3. Шалгагдагч байгууллага нь хот дотор суудлын авто машинд 1.2 сая төгрөгийн шатахуун зарцуулсан байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-т "Энэ хуулийн 3.1-д заасан этгээд орон нутагт албан томилолтоор, хуульд заасан эрх бүхий этгээд газар дээрх хяналт шалгалтаар ажиллахад хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, эсхүл төрийн болон орон нутгийн өмчийн авто тээврийн байгууллагаар үйлчлүүлэхээс бусад тохиолдолд автомашин ашиглахыг хориглоно." гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Хот дотор суудлын авто машинд шатахуун зарцуулсан зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх албан шаардлага өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн хүрээнд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хуулийн холбогдох заалтуудтай нийцсэн, бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлсийг холбогдох шалгуурт нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2023 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланг хамруулж, өмнөх аудитын хэрэгжилт, шилэн данс, мөнгөн хөрөнгө, бараа материал, авлага, өр төлбөр, зардлын данснуудын хувьд горим, сорил хэрэгжүүлсэн.

Завсрын аудитаар 395,973.5 сая төгрөгийн 18 алдааг залруулах зөвлөмжийг асуудлын бүртгэлээр шалгагдагч байгууллагад танилцуулан баталгаажуулж, жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дахин хянаж, үр дүнг аудитын тайланд тусгасан.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн "Тус компанийн санхүүгийн ажилтнууд нь шинээр нэмэгдсэн үйл ажиллагааны чиглэлийн нягтлан бодох бүртгэлийн бодлого арга зүйг стандарт нийцүүлэн боловсруулж, НБББББ-т өөрчлөлтийг нэмэлт зардал гаргахгүйгээр тусгаж, мөрдөн ажиллах" зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитаар өгсөн		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	341.8	1	341.8	100.0
Албан шаардлага	2	15,140.5	1	7,220.1	50.0
Зөвлөмж	3	40,900.9	1	31,194.2	33.3
Нийт дүн	6	56,383.2	3	38,756.1	61.1

/мянган төгрөгөөр/

Өмнөх аудитаар өгсөн авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй 1 албан шаардлага, төлбөрийн цахим төлбөрийн баримтын бүрдэл хангаагүй гүйлгээ хийгдсэн, бодлогын өөрчлөлтийг НБББББ-т тусгаагүй 2 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, давтан гаргасан асуудалд албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

Авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй асуудалд хариуцлага тооцох холбогдох албан тушаалтан ажлаас чөлөөлөгдсөн тул дахин албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг, эрсдэлийн сан болон татан төвлөрүүлсэн хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалт, дотоод хяналтын үйл ажиллагааны үр дүн, бусдад ашиглуулж байгаа газар, түүнтэй холбоотой хөрөнгийн асуудлыг эрх бүхий байгууллагаар шийдвэрлүүлсэн байдал, Сангийн яамны Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газраас хийсэн хяналт шинжилгээ үнэлгээний тайлангаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үндсэн хөрөнгийн бодит үнэ цэний хэмжилт, үнэлгээ зэргийг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.



5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 22,055.7 сая төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 21,823.4 сая төгрөгийн алдааг залруулж, 232.3 сая төгрөгийн алдааг дахин давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа:

НББОУС 8 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, Нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлт ба Алдаа 41-д "Алдаа нь санхүүгийн тайлангийн элементүүдийн хүлээн зөвшөөрөлт, хэмжилт, толилуулга, болон тодруулгатай холбоотойгоор үүсэж болох юм. Санхүүгийн тайлан нь материаллаг алдааг эсвэл аж ахуйн нэгжийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээний тухайлсан тодорхой нэг толилуулгад хүрэхийн тулд санаатайгаар хийсэн материаллаг бус алдааг агуулж байвал СТОУС-тай үл нийцнэ. Тайлант үед илрүүлсэн уг тайлант үеийн боломжит алдааг тухайн санхүүгийн тайланг гаргахыг зөвшөөрөхөөс өмнө засварладаг. Гэвч заримдаа, материаллаг алдааг дараагийн тайлант үе хүртэл илрүүлж чаддаггүй бөгөөд тэдгээр өмнөх үеийн алдааг тухайн дараагийн тайлант үеийн санхүүгийн тайланд толилуулсан зэрэгцүүлэгдэх мэдээлэлд засварладаг." гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын үнэлгээ ба хуваарилалт, оршин байх, толилуулга батламж мэдэгдлийг хангаагүй дараах ажил гүйлгээг аудитын явцад залрууллаа. Үүнд:

- Байгууллагад тасралтгүй 12 сар ажиллаагүй ажилтанд татварын хөнгөлөлтийн давтан тооцооллыг хийж 0.4 сая төгрөгийн хувь хүний орлогын албан татварын авлага, цалингийн өглөг бүртгэснийг;
- Тайлант онд зохион байгуулсан бизнес уулзалт, ажилчдын эрүүл мэндийг дэмжих зорилгоор зохион байгуулсан арга хэмжээний спорт заалны түрээсийн төлбөр, байгууллагын өндөр настанд зарцуулсан нийт 11.7 сая төгрөгийн зардлыг татвар ногдох орлогоос хасагдахгүй зардлаар бүртгэж, ААНОАТ-т тайлагнасныг;
- Тайлант онд гадаад валютаар илэрхийлсэн урьдчилж орсон орлогын гүйлгээнд ханшийн тэгшитгэл тооцож бүртгэсний улмаас 2.6 сая төгрөгийн ГВХЗ бодит бус олз, 4.3 сая төгрөгийн ГВХЗ бодит бус гарзын гүйлгээг бүртгэж, орлого үр дүнгийн тайланд 1.7 сая төгрөгийн бодит бус гарзыг тайлагнасныг;
- Тайлант онд гадаад валютаар илэрхийлсэн урьдчилж төлсөн зардлын гүйлгээнд ханшийн тэгшитгэл тооцсоны улмаас 0.05 сая төгрөгийн ГВХЗ бодит бус гарз, 2.9 сая төгрөгийн ГВХЗ бодит бус олзны гүйлгээг бүртгэж, орлого үр дүнгийн тайланд 2.9 сая төгрөгийн бодит бус олзыг бүртгэж, тайлагнасныг;
- Тайлант онд гадаад валютаар илэрхийлсэн урьдчилж орсон орлогыг борлуулалтын орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэхдээ ханшийн зөрүү тооцоогүйн улмаас 1.4 сая төгрөгийн ГВХЗ бодит гарз, 0.03 сая төгрөгийн ГВХЗ бодит олзыг нягтлан бодох бүртгэлд бүртгээгүй, орлого үр дүнгийн тайланд 1.4 сая төгрөгийн бодит гарзыг тайлагнаагүйг;
- Global mongolia SL харилцагчийн оны эцсийн өглөгийн үлдэгдэл 213.1 сая төгрөг ба тулган баталгаажуулалтаар 1,107.04 USD-ийн үлдэгдлийг тухайн өдрийн ханшаар хөрвүүлээгүй зөрүүтэй тайлагнасныг;
- Тайлант онд гадаад валютаар илэрхийлсэн авлага, өр төлбөрт ханшийн тэгшитгэлийг өдөр бүр тооцоноос 6,857.3 сая төгрөгийн бодит бус олз, 14,085.8 сая төгрөгийн гарз, нийт 20,943.1 сая төгрөгийн ажил гүйлгээг бүртгэснийг;

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/;

- Завсрын аудитаар биетээр байхгүй байсан 13.2 сая төгрөгийн бусад эргэлтийн хөрөнгө нь, Сэлэнгэ аймгийн Баруун бүрэн сум дахь шалгагдагч байгууллагын эзэмших эрх бүхий газар тариалангийн зориулалттай 304 га газрыг борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгөнд залруулан бүртгэснийг;
- Тайлант онд Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан "Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжаа, төлбөр тооцоо хийх ерөнхий журам"-ын 6.6-д заасны дагуу 635.8 сая төгрөгийн Уул уурхайн биржийн эрсдэлийн нөөцийн санг байгуулахдаа Уул уурхайн биржийн эрсдэлийн сангийн зардлаар бүртгэж, татвар ногдуулах орлогоос хасаж тайлагнасныг тус тус залруулав.

Залруулаагүй алдаа:

- Нийт 37 байгууллагын 232.3 сая төгрөгийн найдваргүй авлагын үлдэгдлийг, санхүүгийн программын тохиргооноос шалтгаалан авлагыг сөрөг утгатайгаар бүртгэж авлагыг бууруулж, бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2-т "давхар бичилт" гэж ажил, гүйлгээг дансны дебет, кредитэд зэрэг бичилт хийхийг;" 20.2.5-д "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасныг тус тус мөрдөөгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх, оршин байх, толилуулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Санхүүгийн программд тохируулга хийж, үнэн зөв тайлагнаж байх

- ТУЗ-ийн "Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах тухай 2023 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн 08 дугаар тогтоолоор Компанийн албан ёсны оноосон нэрийг "Монголын хөрөнгийн бирж УУББ"ХК болгон өөрчлөхөөр тогтоосон боловч компанийн улсын бүртгэлийн гэрчилгээнд өөрчлөлт оруулаагүй байна.

Энэ нь Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.3-т "Дүрэмд оруулсан нэмэлт, өөрчлөлт", 22.3.6-д "Улсын бүртгэлийн гэрчилгээ" гэж заасныг мөрдөөгүй байна.

Өгсөн зөвлөмж: ТУЗ-ийн тогтоолыг хэрэгжүүлж гэрчилгээ, дүрэмд тусгах эсэх асуудлыг ХЭХ-аар шийдвэрлэх

Аудитаар нийт 528.7 сая төгрөгийн зөрчил² илэрснээс, 1.8 сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 71.8 сая төгрөгийн зөрчилд 7 албан шаардлага хүргүүлж, 455.1 сая төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 528.7 сая төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 461.7 мянган төгрөгөөр давсан тул Хязгаарлалттай дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

1. Албан томилолтоор ажилласан 2 ажилтны цалин хөлсийг тооцоолохдоо, томилолтоор ажилласан хугацаанд 0.2 сая төгрөгийн хоол унааны нэмэгдлийг давхардуулан олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолын хавсралт "Төрийн албан хаагчид нөхөн төлбөр олгох журам"-ын 2.2-т "Албан томилолтоор ажиллах үеийн нөхөх

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

төлбөр дараах зардлаас бүрдэнэ" 2.2.3-т "Хоолны зардал" гэж гэж заасныг мөрдөөгүй, санхүүгийн тайлагналын үнэн зөв байх, үнэлгээ ба хэмжилт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хоол, унааны нөхөн олговрыг давхардуулан олгосныг буруутай ажилтнаар төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

2. Албан томилолтын зардлыг анхан шатны баримттай тулган шалгахад давхардсан тоогоор 6 хүнд 1.6 сая төгрөгийн албан томилолтын зардлыг илүү олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", Монгол Улсын Засгийн газрын 2019 оны "Журам батлах тухай" 6 дугаар тогтоолоор баталсан хавсралт "Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын 2 дугаар зүйлийн 2.4-т "Албан томилолтоор ажилласан хоногийн тоог албан томилолтоор ажиллуулах шийдвэрт тэмдэглэсэн хуанлийн хоногоор тооцож гаргана. Албан томилолтоор явсан, буцаж ирсэн өдрийг нэгтгэн нэг хоногт тооцно" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын үнэн зөв байх, иж бүрэн байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Томилолтыг илүү тооцож олгосныг буруутай ажилтнаар төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

1. Худалдан авсан хөрөнгө, материалын дүн нь бэлтгэн нийлүүлэгч байгууллагын төлбөрийн цахим системд бүртгэсэн төлбөрийн цахим баримтын дүнгээс 7 иргэн, байгууллагын дүн 0.8 сая төгрөгөөр илүү, 27 иргэн байгууллагын дүн 5.6 сая төгрөгөөр дутуу дүнгээр бүртгэгдсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 "анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.2.4-д "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.6-д "Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй", гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын үнэлгээ, нийцсэн бөгөөд зохистой байх, иж бүрэн байх, тохиолдсон байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг биелүүлээгүй, төлбөрийн цахим системд бүртгэгдсэн и-баримтыг үндэслэн ажил гүйлгээг бүртгээгүй зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

2. Шалгагдагч байгууллага нь 1.3 сая төгрөгийн 383.47 литр шатахууныг авто машин ашиглалтын гэрээгүй, замын хуудсаар тооцоог бодоогүй олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13 дугаар зүйлийн 13.7.-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 18 дугаар зүйлийн 18.1-т "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ." гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: автомашины ашиглалтын гэрээгүй, замын хуудсаар тооцоог бодоогүй шатахууны зардал гаргасан зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

3. Сэлэнгэ аймгийн Баруун бүрэн сум дахь шалгагдагч байгууллагын эзэмших эрх бүхий газар тариалангийн зориулалттай 304 га газрыг 2014 оны 10 дугаар сарын 13-ны өдөр тус аймгийн "Бүрэн Эрдэнэ монос" ХХК-д худалдаж, тус компани нь газрын үнэ 19.8 сая төгрөгийг 3 жилийн хугацаанд төлж барагдуулахаар худалдах худалдан авах гэрээ байгуулсан байна. Уг гэрээ нь хууль тогтоомжид нийцээгүй тул худалдан авах талын газрын үнэнд төлсөн 19.8 сая төгрөгийг өглөгөөр бүртгэж, газрыг бусад эргэлтийн хөрөнгөөр одоог хүртэл бүртгэж, тайлант онд газрын төлбөрт 0.3 сая төгрөг төлж үргүй зардал гаргасан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8/-д "Төрийн өмчит хуулийн этгээдийн үл хөдлөх болон үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийг данснаас хасах санал, захиалгыг хянаж батлах, шинээр авах шийдвэр гаргах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4-т "Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажуулаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх;" гэж заасныг мөрдөөгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Компанийн эзэмшил дэх тариалангийн газрыг "Бүрэн Эрдэнэ монос" ХХК-д олон жил үнэ төлбөргүй ашиглуулсан, өр төлбөрийг барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

4. Авлагын дэлгэрэнгүй бүртгэлийг тулган шалгахад 19 харилцагчийн 22.4 сая төгрөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасныг мөрдөөгүй санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

5. Өглөгийн дэлгэрэнгүй бүртгэлийг тулган шалгахад 20 харилцагчийн 3.4 сая төгрөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасныг мөрдөөгүй санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

6. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны зардлыг Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолоор батлаагүй, зорилтот түвшинд удирдлагын зардалд 151.4 сая төгрөгийг баталснаас гүйцэтгэлээр 152.8 сая төгрөгийн зардал гаргаж батлагдсан төлөвлөгөөг 1.4 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан нь Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13-т "Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох;", компанийн дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.8.13-т "ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох" гэж заасныг мөрдөөгүй, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Удирдлагын зардлыг хэтрүүлсэн зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

7. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн "Тус компанийн санхүүгийн ажилтнууд нь шинээр нэмэгдсэн үйл ажиллагааны чиглэлийн нягтлан бодох бүртгэлийн бодлого арга зүйг стандарт нийцүүлэн боловсруулж, НБББББ-т өөрчлөлтийг нэмэлт зардал гаргахгүйгээр тусгаж, мөрдөн ажиллах" зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3-т "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлсэн ажил, түүний үр дүнг төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд мэдэгдэнэ.20.5-д " Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ." гэж заасныг мөрдөөгүй, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, бодлогын өөрчлөлтийг НБББББ-т тусгаагүй зөрчлийг арилгаж, давтан гаргасан асуудалд албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 75 төрлийн 11.0 сая төгрөгийн анхны өртөгтэй үндсэн хөрөнгө бүртгэлтэй нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 2-т "Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар үндсэн хөрөнгийг зөвхөн төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын зөвшөөрөлтэйгөөр данснаас хасах буюу борлуулах, устгах эрхтэй" гэж заасныг мөрдөөгүй, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Эрх бүхий байгууллагад уламжлан үндсэн хөрөнгийг бодит үнэ цэнээр үнэлж бүртгэх.

2. Дотоод хяналттай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Дотоод хяналтын алба нь тайлант онд гүйцэтгэх ажлын батлагдсан төлөвлөөгүй, хяналт шалгалт хийж 3 зөвлөмж хүргүүлсэн боловч хэрэгжилтийг тооцоогүй нь Компанийн тухай хуулийн 81.4.1-т "Компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийг олон улсын стандартад нийцүүлэх, дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа, санхүүгийн тайлан, санхүү, эдийн засгийн бусад мэдээллийн үнэн бодит байдалд хяналт тавих", Компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.14-т "Гүйцэтгэх захирлын зөвлөлийн хуралдаанаар Дотоод хяналтын албаны мэдээлэл, шалгалтын дүнг улирал бүрх хэлэлцэн, холбогдох арга хэмжээг авч ажиллана" гэж заасныг мөрдөөгүй, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Дотоод хяналтын албаны сар, улирал, жилийн ажлын төлөвлөгөөг боловсруулж, санхүүгийн тайлангийн аудит болон Сангийн яамны СХЭУГ-ын хяналт шинжилгээ үнэлгээний тайлангаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллах.

3. Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалттай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Татан төвлөрүүлсэн 11,915.8 сая төгрөгийн хөрөнгөөс тайланд онд 1,487.1 сая төгрөгийг зарцуулснаас МIТ системийн ашиглалтын зардалд жил бүр төлдөг урсгал зардалд 455.1 сая төгрөгийг зарцуулсан нь Үнэт цаасны зах зээлийн тухай тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.5.11-д "Үнэт цаас гаргаж хуримтлуулсан хөрөнгийг зарцуулах бизнес төлөвлөгөө"-д гэж заасныг мөрдөөгүй, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг, толилуулга батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Татан төвлөрүүлсэн хөрөнгийг биржийн үйл ажиллагааг өргөжүүлэх, бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх, шинэ техник технологи нэвтрүүлж, үр ашгийг нэмэгдүүлсэн байхаар төлөвлөж зарцуулах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2024 оны 9 дүгээр сарын 02-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Байгууллагад тасралтгүй 12 сар ажиллаагүй ажилтанд татварын хөнгөлөлтийн давтан тооцооллыг хийж 0.4 сая төгрөгийн хувь хүний орлогын албан татварын авлага, цалингийн өглөгийг бүртгэсэн байна.	1	0.4	-	-	1	0.4	1	0.4	-	-	-	-
Тайлант онд зохион байгуулсан бизнес уулзалт, ажилчдын эрүүл мэндийг дэмжих зорилгоор зохион байгуулсан арга хэмжээний спорт заалны түрээсийн төлбөр, байгууллагын өндөр настанд зарцуулсан нийт 11.7 сая төгрөгийн зардлыг татвар ногдох орлогоос хасагдахгүй зардлаар бүртгэж, ААНОАТ-т тайлагнасан байна.	1	11.7	-	-	1	11.7	1	11.7	-	-	-	-
Тайлант онд гадаад валютаар илэрхийлсэн урьдчилж орсон орлогын гүйлгээнд ханшийн тэгшитгэл тооцож бүртгэсний улмаас 2.6 сая төгрөгийн ГВХЗБодит бус ола, 4.3 сая төгрөгийн ГВХЗБодит бус гарзын гүйлгээг бүртгэж, Орлого үр дүнгийн тайланд 1.7 сая төгрөгийн бодит бус гарзыг тайлагнасан байна.	1	1.7	-	-	1	1.7	1	1.7	-	-	-	-
Тайлант онд гадаад валютаар илэрхийлсэн урьдчилж төлсөн зардлын гүйлгээнд ханшийн тэгшитгэл тооцсоны улмаас 0.05 сая төгрөгийн ГВХЗБодит бус гарз, 2.9 сая төгрөгийн ГВХЗБодит бус олзны гүйлгээг бүртгэж, орлого үр дүнгийн тайланд 2.9 сая төгрөгийн бодит бус олзыг тайлагнасан байна.	1	2.9	-	-	1	2.9	1	2.9	-	-	-	-
Тайлант онд гадаад валютаар илэрхийлсэн урьдчилж орсон орлогыг борлуулалтын орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэхдээ	1	1.4	-	-	1	1.4	1	1.4	-	-	-	-

Монголын хөрөнгийн бирж ХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

ханшийн зөрүү тооцоогүйн улмаас 1.4 сая төгрөгийн ГВХЗБодит гарз, 0.03 сая төгрөгийн ГВХЗБодит олзыг нягтлан бодох бүртгэлд бүртгээгүй, орлого үр дүнгийн тайланд 1.4 сая төгрөгийн бодит гарзыг тайлагнаагүй байна.												
Global Mongolia SL харилцагчийн оны эцсийн өглегийн үлдэгдэл 213.1 сая төгрөг ба тулган баталгаажуулалтаар 1,107,04 USD ийн үлдэгдлийг тухайн өдрийн ханшаар хөрвүүлээгүй зөрүүтэй тайлагнасан байна.	1	213.1	-	1	213.1	1	213.1	-	-	-	-	-
Тайлант онд гадаад валютаар илэрхийлсэн авлага, ер төлбөрт ханшийн тэгшитгэлийг өдөр бүр тооцоноос 6,857.3 сая төгрөгийн бодит бус олз, 14,085.8 сая төгрөгийн гарз, нийт 20,943.1 сая төгрөгийн ажил гүйлгээг бүртгэсэн байна.	1	20,943.1	-	1	20,943.1	1	20,943.1	-	-	-	-	-
Завсрын аудитаар биетээр байхгүй байсан 13.2 сая төгрөгийн бусад эргэлтийн хөрөнгө нь, Сэлэнгэ аймгийн Баруун бүрэн сум дахь шалгагдагч байгууллагын эзэмших эрх бүхий газар тариалангийн зориулалттай 304 га газрыг борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгөнд залруулан бүртгэсэн нь стандарт, хууль, заавар журамд нийцэхгүй байна.	1	13.2	-	1	13.2	1	13.2	-	-	-	-	-
Тайлант онд Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан "Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжаа, төлбөр тооцоо хийх ерөнхий журам"-ын 6.6-д заасны дагуу 635.8 сая төгрөгийн Уул уурхайн биржийн эрсдэлийн нөөцийн санг байгуулахдаа Уул уурхайн биржийн эрсдэлийн сангийн зардлаар бүртгэж, татвар ногдуулах орлогоос хасаж тайлагнасан байна.	1	635.9	-	1	635.9	1	635.9	-	-	-	-	-
Нийт 37 байгууллагын 232.3 сая төгрөгийн найдваргүй авлагын үлдэгдлийг, санхүүгийн программын тохиргооноос шалтгаалан авлагыг сөрөг утгатайгаар бүртгэж авлагыг бууруулж, бүртгэсэн байна.	1	232.3	-	1	232.3	-	232.3	-	1	232.3	1	232.3

Монголын хөрөнгийн бирж ХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

ТУЗ-ийн "Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах тухай 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 08 дугаар тогтоолоор Компанийн албан ёсны оноосон нэрийг "Монголын хөрөнгийн бирж УУББ"ХК болгон өөрчлөхөөр тогтоосон боловч компанийн улсын бүртгэлийн гэрчилгээнд өөрчлөлт оруулаагүй байна.	1	-	1	-	-	-	-	-	1	-	-	1
Дүн	11	22,055.7	1	-	10	22,055.7	9	21,823.4	2	232.3	2	232.3

Монголын хөрөнгийн бирж ХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан
6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

	Зөрчлийн товч утга	Үүнээс										/сая төгрөгөөр/	
		Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	Албан томилолтоор ажилласан 2 ажилтны цалин хөлсийг тооцоолохдоо, томилолтоор ажилласан хугацаанд 0.2 сая төгрөгийн хоол унааны нэмэгдлийг давхардуулан олгосон байна.	1	0.2	1	0.2	-	-	-	-	-	-	-	
	Худалдан авсан хөрөнгө, материалын дүн нь бэлтгэн нийлүүлэгч байгууллагын төлбөрийн цахим системд бүртгэсэн төлбөрийн цахим баримтын дүнгээс 7 иргэн, байгууллагын дүн 0.8 сая төгрөгөөр илүү, 27 иргэн байгууллагын дүн 5.6 сая төгрөгөөр дутуу дүнгээр бүртгэгдсэн байна.	1	6.4	-	-	1	6.4	-	-	-	-	-	
	Шалгагдагч байгууллага нь 1.3 сая төгрөгийн 383.47 литр шатахууныг авто машин ашиглалтын гэрээгүй, замын хуудсаар тооцоог бодоогүй олгосон байна.	1	1.3	-	-	1	1.3	-	-	-	-	-	
	Албан томилолтын зардлыг анхан шатны баримттай тулган шалгахад давхардсан тоогоор 6 хунд 1.6 сая төгрөгийн албан томилолтын зардлыг илүү олгосон байна.	1	1.6	1	1.6	-	-	-	-	-	-	-	
	Элэгдлээрээ анхны өртөө нөхсөн 75 төрлийн 11.0 сая төгрөгийн анхны өртөгтэй үндсэн хөрөнгө бүртгэлтэй байна.	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	
	Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн "Тус компанийн санхүүгийн ажилтнууд нь шинээр нэмэгдсэн үйл ажиллагааны чиглэлийн нягтлан бодох бүртгэлийн бодлого арга зүйг стандартад нийцүүлэн боловсруулж, НБББББ-т өөрчлөлтийг нэмэлт зардал гаргахгүйгээр тусгаж, мөрдөн ажиллах" зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна	1	-	-	-	1	-	-	-	-	-	-	

Монголын хөрөнгийн бирж ХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

<p>Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сум дахь шалгадагч байгууллагын эзэмших эрх бүхий газар тариалангийн зориулалттай 304 га газрыг 2014 оны 10 дугаар сарын 13-ны өдөр тус аймгийн "Бүрэн Эрдэнэ монос" ХХК-д худалдаж, тус компани нь газрын үнэ 19.7 сая төгрөгийг 3 жилийн хугацаанд төлж барагдуулахаар худалдах, худалдан авах гэрээ байгуулсан байна. Уг гэрээ нь хууль тогтоомжид нийцээгүй тул худалдан авах талын газрын үнэнд төлсөн 19.7 сая төгрөгийг өглөгөөр бүртгэж газрыг "Бүрэн Эрдэнэ монос" ХХК-д олон жил үнэ төлбөргүй ашиглуулж, тайлант онд газрын төлбөрт 0.3 сая төгрөг төлж үргүй зардал гаргасан байна.</p>	1	20.0	-	-	1	20.0	-	-	-	-
<p>Дотоод хяналтын алба нь тайлант онд гүйцэтгэх ажлын батлагдсан төлөвлөөгүй, хяналт шалгалтыг 1 удаа хийж 3 зөвлөмж хүргүүлсэн боловч хэрэгжилтийг тооцоогүй байна.</p>	1	-	-	-	-	-	1	-	-	-
<p>Татан төвлөрүүлсэн 11,915.8 сая төгрөгийн хөрөнгөөс тайланд онд 1,487.1 сая төгрөгийг зарцуулснаас МИТ системийн ашиглалтын зардалд жил бүр төлдөг урсгал зардалд 455.1 сая төгрөгийг зарцуулсан байна.</p>	1	455.1	-	-	-	-	1	-	-	455.1
<p>Авлагын дэлгэрэнгүй бүртгэлийг тулган шалгахад 19 харилцагчийн 22.4 сая төгрөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.</p>	1	22.4	-	-	1	22.4	-	-	-	-
<p>Өглөгийн дэлгэрэнгүй бүртгэлийг тулган шалгахад 20 харилцагчийн 3.4 сая төгрөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.</p>	1	3.4	-	-	1	3.4	-	-	-	-
<p>ТУЗ-ийн 2023 оны зардлыг ХЭХ-ын тогтоолоор батлаагүй, зорилтот түвшинд удирдлагын зардалд 151.4 сая төгрөгийг баталснаас гүйцэтгэлээр 152.8 сая төгрөгийн зардал гаргаж батлагдсан төлөвлөгөөг 1.4 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна.</p>	1	1.4	-	-	1	1.4	-	-	-	-
<p>Дүн</p>	12	511.8	2	1.8	7	54.9	3	455.1	-	-

Монголын хөрөнгийн бирж ХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан
6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс				Зөвлөмж
			Албан шаардлага				
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил							
Шалгагдагч байгууллагын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 1 суудлын автомашины улсын дугаар цагаан өнгөтэй байна.	1	-	-	-	1	-	-
ТУЗ-ын 2023 оны 27 дугаар тогтоолоор 13 нэр төрлийн 9,783.7 сая төгрөгийн орлогын төлөвлөгөөг баталснаас гишүүн байгууллагын хураамжийн орлого, төмрийн арилжааны шимтгэл, бусад орлого, банкны хүүгийн орлого, нүүрсний арилжааны шимтгэлийн орлого нийт 5 төрлийн орлогын төлөвлөгөө 32.7-4,224.2 сая төгрөгөөр давж, 8 нэр төрлийн орлогын төлөвлөгөө 8.3-1,179.3 сая төгрөгөөр тасарсан байна.	1	1,855.8	-	-	1	1,855.8	1,855.8
Шалгагдагч байгууллага нь хот дотор суудлын авто машинд 1.2 сая төгрөгийн шатахуун зарцуулсан байна.	1	1.2	1	1.2	-	-	-
Дүн	3	1,857.0	1	1.2	2	1,855.8	1,855.8

/сая төгрөгөөр/